



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ГАА-2022/107/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудиторын туслах: Ч.Даваасүрэн Утас: 99559722      Цахим хаяг: <a href="mailto:daavkach@gmail.com">daavkach@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	7
3.1 Ерөнхий зүйл .....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт .....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	12

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЕСӨНБУЛАГ СУМЫН 2-Р  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.СҮРЭНХҮҮ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 76

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

07020085

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,444,933.39</b>	<b>81,439,390.38</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	4,443,042.01	4,430,140.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	4,430,140.00	4,430,140.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,430,140.00	4,430,140.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	65,001,891.38	77,009,250.38
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	22,263,386.12	37,403,023.12
35110	Тусгай зориулалттай материал	22,223,386.12	37,061,386.12
35130	Эм боох материал	40,000.00	341,637.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	42,738,505.26	39,606,227.26
35410	Бичиг хэргийн материал	1,522,380.00	1,503,180.00
35420	Аж ахуйн материал	8,886,266.00	8,137,266.00
35450	Барилгын засварын материал	812,400.00	651,600.00
35460	Хүнсний материал	1,379,412.00	533,000.00
35470	Бусад хангамжийн материал	30,138,047.26	28,781,181.26
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>438,571,518.12</b>	<b>420,339,532.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	438,571,518.12	420,339,532.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	394,001,518.12	375,829,532.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	410,382,479.60	410,382,479.60
39202	Хуримтлагдсан элэгдэл	(48,644,290.24)	(75,994,247.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,439,313.00	26,763,313.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,397,546.41)	(11,870,637.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,484,561.00	32,800,632.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,296,332.21)	(7,585,339.60)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,900,000.00	5,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,866,666.62)	(4,566,666.58)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	44,570,000.00	44,510,000.00
39301	Програм хангамж	790,000.00	790,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(580,000.00)	(640,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,360,000.00	44,360,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>508,016,451.51</b>	<b>501,778,923.37</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>508,016,451.51</b>	<b>501,778,923.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	508,016,451.51	501,778,923.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,215,357.00	189,215,357.00
51101	Өмч: - төрийн	189,215,357.00	189,215,357.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(20,456,433.67)	(26,693,961.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(56,980,809.18)	(20,456,433.67)
51220	Тайлант үеийн үр дүн	36,524,375.51	(6,237,528.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	339,257,528.18	339,257,528.18
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>508,016,451.51</b>	<b>501,778,923.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>439,614,529.00</b>	<b>388,958,043.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>67,146,429.00</b>	<b>4,589,743.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	67,146,429.00	4,589,743.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,146,429.00	4,589,743.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	67,146,429.00	4,589,743.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		224,956.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал		4,364,787.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>372,468,100.00</b>	<b>384,368,300.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	317,732,700.00	343,619,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	317,732,700.00	343,619,300.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,586,400.00	-
131104	дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчил хуваарилсан хөрөнгө	4,586,400.00	
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	50,149,000.00	40,749,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,149,000.00	40,749,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>403,090,153.49</b>	<b>395,195,571.14</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>403,090,153.49</b>	<b>395,195,571.14</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	384,477,322.27	380,629,021.67
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	256,614,945.00	247,742,868.01
210101	Үндсэн цалин	235,170,158.00	225,867,825.41
210104	Урамшуулал	21,444,787.00	21,875,042.60
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,348,182.10	32,736,217.00
210201	Тэтгэврийн даатгал	25,056,118.99	22,806,243.00
210202	Тэтгэмжийн даатгал	487,401.00	2,467,492.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,845,199.35	2,000,996.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,596.00	496,499.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,338,866.76	4,964,987.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,817,819.67	40,437,097.37
210301	Гэрэл, цахилгаан	2,919,348.67	2,883,809.37
210302	Түлш, халаалт	30,143,895.00	33,649,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,754,576.00	3,904,288.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,276,960.00	8,566,436.16
210401	Бичиг хэрэг	834,500.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	787,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	326,460.00	812,520.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	376,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,400,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	3,970,016.00
2105	<b>Нормативт зардал</b>	15,134,166.00	10,982,462.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	595,000.00	715,000.00
210502	Хоол, хүнс	14,539,166.00	10,267,462.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,873,000.00	-
210604	Урсгал засвар	3,873,000.00	
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	343,200.00	-
210702	Дотоод албан томилолт	343,200.00	
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	706,000.00	1,103,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	382,000.00	
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,363,049.50	39,060,941.13
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,099,000.00	504,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,264,049.50	38,556,941.13
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,612,831.22	14,566,549.47
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	6,346,400.00	1,467,000.00
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,586,400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,467,000.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	9,331,180.33	311,902.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,331,180.33	311,902.63
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,935,250.89	12,787,646.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,935,250.89	12,787,646.84
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>36,524,375.51</b>	<b>(6,237,528.14)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>36,524,375.51</b>	<b>(6,237,528.14)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-20,456,433.67	508,016,451.51
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-20,456,433.67	508,016,451.51
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-20,456,433.67	508,016,451.51
D01	2021оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-20,456,433.67	508,016,451.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-20,456,433.67	508,016,451.51
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-6,237,528.14	-6,237,528.14
D09	2021оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,215,357.00	339,257,528.18	-26,693,961.81	501,778,923.37

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	372,468,100.00	384,368,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	372,468,100.00	384,368,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	317,732,700.00	343,619,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	317,732,700.00	343,619,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,149,000.00	40,749,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,149,000.00	40,749,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	367,988,100.00	364,268,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	367,988,100.00	364,268,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,375,268.78	349,701,750.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256,614,945.00	247,729,966.00
210101	Үндсэн цалин	235,170,158.00	225,854,923.40
210104	Урамшуулал	21,444,787.00	21,875,042.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,361,084.11	32,736,217.00
210201	Тэтгэврийн даатгал	25,069,021.00	22,806,243.00
210202	Тэтгэмжийн даатгал	487,401.00	2,467,492.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,845,199.35	2,000,996.00
210204	Ажилгүйдлийн даатгал	620,596.00	496,499.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,338,866.76	4,964,987.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,817,819.67	40,437,097.37
210301	Гэрэл, цахилгаан	2,919,348.67	2,883,809.37
210302	Түлш, халаалт	30,143,895.00	33,649,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,754,576.00	3,904,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,276,960.00	4,769,420.16
210401	Бичиг хэрэг	834,500.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	240,000.00	787,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	326,460.00	812,520.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	376,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,000.00	2,573,000.00
2105	Нормативт зардал	13,156,260.00	16,826,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	595,000.00	715,000.00
210502	Хоол, хүнс	9,671,360.00	9,421,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,889,900.00	6,690,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	706,000.00	1,103,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,099,000.00	6,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,099,000.00	6,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,612,831.22	14,566,549.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,346,400.00	1,467,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,760,000.00	1,467,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,331,180.33	311,902.63
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,331,180.33	311,902.63
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,935,250.89	12,787,646.84
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,935,250.89	12,787,646.84
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,480,000.00	20,100,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,480,000.00	20,100,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,480,000.00	20,100,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,480,000.00	20,100,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,480,000.00	20,100,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,480,000.00)	(20,100,000.00)

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	384,368,300.00	371,268,750.53
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	384,368,300.00	371,268,750.53
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	382,901,300.00	369,801,750.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	255,502,000.00	247,729,966.00
210101	Үндсэн цалин	233,002,000.00	225,854,923.40
210104	Урамшуулал	22,500,000.00	21,875,042.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	34,144,900.00	32,736,217.00
210201	Тэтгэврийн даатгал	23,758,000.00	22,806,243.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,584,700.00	2,467,492.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,089,300.00	2,000,996.00
210204	Ажилгүйдлийн даатгал	519,500.00	496,499.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,193,400.00	4,964,987.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	40,749,000.00	40,437,097.37
210301	Гэрэл, цахилгаан	2,900,000.00	2,883,809.37
210302	Түлш, халаалт	33,649,000.00	33,649,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	3,904,288.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,559,000.00	4,769,420.16
210401	Бичиг хэрэг	500,000.00	500,000.00
210402	Тээвэр, шатахуун	790,000.00	787,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600,000.00	812,520.16
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,573,000.00	2,573,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	19,638,400.00	16,826,050.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	715,000.00	715,000.00
210502	Хоол, хүнс	12,233,400.00	9,421,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,690,000.00	6,690,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	20,100,000.00	20,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,100,000.00	10,100,000.00
210602	Тавилга	10,000,000.00	10,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй</b>	1,108,000.00	1,103,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	460,000.00	455,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,100,000.00	6,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,100,000.00	6,100,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,467,000.00	1,467,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,467,000.00	1,467,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,467,000.00	1,467,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	384,368,300.00	371,268,750.53
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	343,619,300.00	330,831,653.16
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	343,619,300.00	330,831,653.16
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	40,749,000.00	40,437,097.37
132001	Орон нутгийн төсвөөс	40,749,000.00	40,437,097.37

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай аймаг дахь салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдрын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 439.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 7.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатны материаллаг байдлыг тайлант оны нийт орлого 388.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.23 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Авлагын эхний үлдэгдэл 4.4 сая төгрөг нь удирдлагын буруутай шийдвэрээс ажлаас халагдсан ажилтанд төсвөөс олгосон цалингийн нөхөн олговор бөгөөд тайлант хугацаанд барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 77.0 сая төгрөг болж 12.0 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26.7 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 4.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 14.5 сая төгрөгийн материалыг зарцуулж, 3.9 сая төгрөг акталж данснаас хассан, 0.7 сая төгрөг аймгийн Онцгой комиссын шийдвэрээр шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 520.9 сая төгрөг болж 17.5 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 20.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч 2.6 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 501.7 сая төгрөг болж 6.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 11.5 хувиар буюу 50.7 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 26.6 сая төгрөгийн алдагдалтай болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 542.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 158.3 сая төгрөгөөр бууруулж, 384.3 сая төгрөгөөр баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 384.3 сая төгрөгийн төсөв баталснаас 343.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 40.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 343.6 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 40.7 сая төгрөгийн нийт 384.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 371.3 сая төгрөгийг зарцуулж 12.7 сая төгрөгийг улсын төсөвт, 0.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 371.3 сая төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 7.7 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 0.7 сая төгрөгөөр, нормативт зардлыг 2.8 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

#### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

##### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 418.6 сая төгрөгийн 36 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 418.6 сая төгрөгийн 36 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан ба 2 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3.5 сая төгрөгийн төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 39.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 36.8 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.9 сая төгрөгийн зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 36.8 сая төгрөгийн алдааг залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Ажилтын амралт, цалинг давхардуулан 0.7 сая төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

Хоолны зардлын нормативыг 0.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны хоолны зардлын норматив тогтоох 450 дугаар тогтоолын 1дүгээр заалт "Цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг, сувиллын болон тусгай цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны

зардлыг 3600 төгрөгөөр тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

#### 4.3 Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлээгүй, давтан гаргасан нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-т "өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх", 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах заалттай нийцсэн тул нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр 1.9 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт" ТБОНӨХ-өөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дэрэмт хувцас, амралт алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар" 43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

#### 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 2 дугаар цэцэрлэг	6	39.7	1	36.8	2	1.0	3	1.9		-

/сая төгрөгөөр/